

**“ИЛ ТОД” БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ 2019 ОНЫ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 онд дэвшүүлсэн 5-н зорилт буюу үйл ажиллагааны стратегийн зорилт зорилго, тэргүүлэх чиглэл болон хүний нөөцийн ил тод байдал, төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм зэргийг тогтмол байршуулан ажиллалаа. Байгууллагын цахим хуудсыг мэдээ мэдээллээр цаг тухайд ханган олон нийтэд хүргэж нийгэмд учирч болох аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллалаа.Тухайн цахим хуудсын мэдээлэл нь Онцлох мэдээ, Цаг үеийн мэдээлэл, Хэвлэлийн бага хурал, Фото мэдээлэл, Хурлын мэдээлэл, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, Байгууллагын мэдээллийн ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, Төсөв санхүүгийн ил тод байдал, Сэрэмжлүүлэг, Зөвлөмж мэдээ, видео мэдээлэл гэсэн ангилалаар мэдээ мэдээллийг тогтмол хүргэлээ. 2019 онд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын цахим хуудсанд бүрэн шинэчлэлт хийж , харъяалах 8 чиглэлийн хэлтэс, 9 дүүрэг, төв лаборатори тус бүр танилцуулга, мэдээ мэдээлэл, холбоо барих гэсэн цэсүүдээр ангилагдсан. Мөн Хяналт шалгалтын төлөвлөгөө болон хяналтын хуудас /татаж авах/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шуурхай хуралдаан, Газрын шуурхай хуралдаан болон Газрын даргын зөвлөлийн хурлын мэдээлэл, төлөвлөгөө, шийдвэр болон байгууллагын бодлогын баримт бичиг, холбогдолтой хууль, дүрэм журам, Засгийн газрын тогтоол, МХЕГ-ын даргын тушаал, албан даалгавар, НЗД-ын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаал, гадаад харилцаа хамтын ажиллагаа гэсэн нэмэлт цэсүүдээс иргэд, бизнес эрхлэгчидийг мэдээлэл авах боломжоор ханган ажилласан байна .</p> <p>Байгууллагын цахим хуудсын мэдээллийн санд нийт 3628 мэдээлэл байршсан байна.Үүнээс Хяналт шалгалт, зөрчлийн мэдээ 917, зөвлөмж 2068, сэрэмжлүүлэг 173, сургалтын мэдээ 233, бусад 118 мэдээлэл байршсан байна. Хурлын мэдээлэл, бодлогын баримт бичиг 12 дотоод журам, шуурхайн дэг, хурлын дэг, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын мэдээлэл 16, хэвлэлийн бага хурлын мэдээлэл 12, гадаад харилцаа хамтын ажиллагаа 8, Видео мэдээлэл 64, Төрийн үйлчилгээ буланд 29, хяналтын хуудас 266 мэдээлэл байршсан. Түүнчлэн “Орон тооны бус зөвлөл”-ийн устгалын мэдээллийг тухай бүр байршууллаа. Байгууллагын мэдээллийн самбарт Хүний нөөц, төсөв санхүү, тайлан мэдээ, худалдан авах ажиллагаа, шаардлагатай бичиг баримт, хэлтсүүдийн чиг үүрэг, утасны жагсаалт, онцлох мэдээлэл гэсэн 8 хэсгээс бүрдэж, тогтмол мэдээллийг шинэчилдэг.</p>	100%
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн	Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн “Үйл ажиллагааны ил тод байдал” булан мөн “Төрийн үйлчилгээ” цэсэнд тус тус байршууллаа. Биелэлт 100%-тай байна.	100%

	авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх		
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулж тухай бүрт шинэчлэх	Байгууллагын цахим хуудас болох ub.inspection.gov.mn - д “Төрийн үйлчилгээ” булан ажиллуулж байна.Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналт, Дэд бүтцийн хяналт, Хүнс, хөдөө аж ахуйн хяналт, Экспорт, импортын хяналт, Цөм болон цацрагийн хяналт, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналт агаарын чанарын хяналт гэсэн хяналтын 8 чиглэл бүрээр бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, дүрэм, журам, зөвлөгөө зөвлөмжийн татаж авах зориулалтаар байршууллаа. Нийт 29 баримт бичгийн жагсаалт байршсан. Мөн мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалт хийхэд ашиглах 266 хяналтын хуудсыг татаж авах хэлбэрээр тухай бүр шинэчлэн байршууллаа. Биелэлт 100%-тай байна.	100%
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Хууль эрх зүй буланд байгууллагын бодлогын баримт бичиг, холбогдолтой хууль, дүрэм журам, Засгийн газрын тогтоол, МХЕГ-ын даргын тушаал, албан даалгавар, НЗД-ын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын А, Б тушаалыг тогтмол нэмж шинэчлэн байршуулж байна. Мэдээллийн самбар хүний нөөц, төсөв санхүү, тайлан мэдээ, худалдан авах ажиллагаа, шаардлагатай бичиг баримт, хэлтсүүдийн чиг үүрэг, утасны жагсаалт, онцлох мэдээлэл гэсэн 8 хэсэгтэй. Тус самбарт давхардсан тоогоор 28 удаа баяжуулалт хийсэн. Биелэлт 100%-тай байна.	100%
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног байршуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	НМХГ-ын даргын тушаалын төсөл буюу хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай мөн дотоод журам шинэчлэн батлах тухай зэрэг бодлогын баримт бичгийн төслийг цахим хуудсанд байршуулж улсын ахлах болон улсын байцаагчдын саналыг авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллалаа. НМХГ-ын 2019 оны “Санал хүсэлт ажиллуулах журам” А/17 дугаар тушаал, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд “Санал хүсэлтийн хайрцаг”-ийн саналыг сард 1 удаа авч нэгтгэж байна. НМХГ-ын төв байр, 6 дүүрэг дэх МХХ, Төв лаборатори,13 гаалийн бүс нийт 21 ажлын байранд санал хүсэлтийн хайрцаг суурилуулсан. Саналын хайрцгуудад НМХГ-ын төв байранд 11, Баянгол-8, Сонгинохайрхан-14, Хан-Уул-6, Баянзүрх-7, Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст-8, Техник импортын гаалийн хяналтын бүсэд 1, Төв лабораторид 28, нийт 83 санал, сэтгэгдэл ирсэн байна. Саналын 48 буюу 85 хувь нь Мэргэжлийн хяналтын байгууллага түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн, мэдээлэл, зөвлөгөө сайн өгч байгаад талархал бичсэн байна. Мөн төв байрны бичиг хэргийн ажилтнууд, 13 улсын /ахлах/ байцаагчдад нэр зааж шуурхай үйлчилгээ үзүүлсэнд талархал илэрхийлжээ.	100%
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	1. Байгууллагын цахим болох ub.inspection.gov.mn - д “Төрийн үйлчилгээ” булан ажиллуулж, Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалт хийхэд ашиглах 266 хяналтын хуудсыг татаж авах хэлбэрээр байршуулсан. Тухайн жилд хяналт шалгалтад хамрагдах объектын нэрсийг олон нийтэд ил тод байршуулсан. 2. Мал амьтан, тэдгээрийн гаралтай экспортын гэрчилгээ олгох нэг цэгийн үйлчилгээг бий болгон 1074 иргэн аж ахуй нэгжид экспортын гэрчилгээ олгож бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, дүрэм, журам, зөвлөгөө зөвлөмжийн татаж авах зориулалтаар байршууллаа.	

		<p>3. Саналын хайрцгуудад НМХГ-ын төв байранд 11, Баянгол-8, Сонгинохайрхан-14, Хан-Уул-6, Баянзүрх-7, Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст-8, Техник импортын гаалийн хяналтын бүсэд 1, Төв лабораторид 28, нийт 83 санал, сэтгэгдэл ирсэн байна. Саналын 48 буюу 85 хувь нь Мэргэжлийн хяналтын байгууллага түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн, мэдээлэл, зөвлөгөө сайн өгч байгаад талархал бичсэн байна. Мөн төв байрны бичиг хэргийн ажилтнууд, 13 улсын /ахлах/ байцаагчдад нэр зааж шуурхай үйлчилгээ үзүүлсэнд талархал илэрхийлжээ.</p>	
7	<p>Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх.</p>	<p>НМХГ 2019 онд Төрийн болон төрийн бус байгууллагуудтай Санамж бичиг байгуулаагүй.Төрийн бус байгууллагуудтай хяналт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилготой хамтран ажилласан явц байдлыг тухай бүр цахим хуудсанд байршуулдаг.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> -Уул уурхайн нөхөн сэргээлтийн MJL олон улсын байгууллага -Шүд холбоо -Монголын шүдний мэргэжилтний холбоо -Түшээ дээд сургууль <p>Төрийн байгууллагуудаас</p> <ul style="list-style-type: none"> -Орчны цаг уур шинжилгээны газар -Нийслэлийн Боловсролын газар -Нийслэлийн Цагдаагийн газар -Нийслэлийн Эрүүл мэндийн газар -Нийслэлийн Газрын алба -Нийслэлийн Онцгой байдлын газар -Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам -Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газар -Цөмийн энергийн комисс зэрэг газруудтай хамтран ажилласан. 	100%
8	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуй үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх</p>	<p>НМХГ нь чиг үүргийн хувьд тусгай зөвшөөрөл олгодоггүй.</p>	
9	<p>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/460 дугаар захирамжаар Мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх ажлын хүрээнд 400 сая төгрөгийн санхүүжилтээр автомашин 8 ширхэг, улсын байцаагч нарт хэрэглэгдэх хяналтын багаж хэрэгсэл 7 ширхэг, компьютер 70 ширхэг, принтер 15 ширхэг, тавилга эд хогшил 182 ширхэг /Бичгийн ширээ -90 ширхэг, сандал 91 ширхэг, шкаф -1 ширхэг/-г тус тус худалдан авах ажиллагааг цахим www.tender.gov.mn сайтаар зохион байгуулан, гэрээ</p>	100%

		хийгдэж багаж, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, тээврийн хэрэгслүүдийг хүлээн авч албан хаагчдыг ажилллах нөхцлөөр ханган ажиллаа. Байгаль Орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/107 дугаар тушаалаар 560 сая төгрөгийн эрх шилжиж ирсэний дагуу явуулын ажлын байр 4 ширхэгийг 148 924 496 төгрөгөөр нээлттэй тендер зарлаж худалдан авсан.	
Хэсгийн дундаж хувь			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	-Төрийн жинхэнэ албан тушаалын сул гарсан Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн, Байгаль орчны, Боловсрол, Геологи уул уурхай, Хэмжил зүй, Тээврийн, Эрүүл ахуйн хяналтын ажлын байрыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөл, Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 02-01/72, 317, 478, 740, 766, 1664, 2351 дүгээр албан бичиг хүргүүлсэн. Мөн сул орон тооны зарыг тухай бүрт Үйл ажиллагааны ил тод байдал болон Байгууллагын ил тод байдал цэсэнд тус тус байршуулсан.	100%
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Ёс зүйн зөвлөл цэсэнд сүүлийн 5 жилийн байдлаар /2015-2019/ Ёс зүйн хорооны тайлангууд, төрийн захиргааны албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээллийг шинэчлэн байршуулсан. Ёс зүйн хороо тус газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/48 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Даргын тушаалаар томилогдсон төрийн захиргааны албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, тэдгээртэй холбоотой ёс зүйн зөрчлийг шалган тогтоох үүрэгтэйгээр ажилладаг.“Хүний нөөцийн ил тод байдал цэсэд төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл”, “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” байршсан. Ёс зүйн хорооны Кодын бүртгэлийг татаж авах хэлбэрээр байршуулан ажиллалаа.	100%
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх.	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө гарган биелэлтийг хангуулан ажиллаж байна. Мөн Ажилд авах, албан тушаал дэвшүүлэх болон холбогдох бусад шийдвэрийг хүний нөөцийн мэдээлэлд үндэслэн удирдлагын түвшинд саналыг авч баталгаажуулдаг. 2019 оны 01 дугаар сарын 20-ны өдөр сургалтын каледарчилсан төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Сургалтын каледарчилсан төлөвлөгөөнд аж ахуй нэгж байгууллагад зориулсан 347 сургалт, албан хаагчдыг чадавхижуулах 300 сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хандсан нийт 512 сургалт зохион байгуулагдаж 6883 ААНБ 19275 ажилтан, иргэд хамрагджээ. Байгууллагын бүтэц орон тоо хүний нөөцийн ил тод байдлын судалгаа, Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг байгууллагын вэб сайтад байршуулсан.	100%
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	НМХГ-ын даргын 2017 оны Б/141 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг, Төрийн албан хаагчдын сургалтын дэд хөтөлбөрийг тус тус баталсан. Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг батлан, биелэлтийг ханган ажиллаж байна. - Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд буцалтгүй тэтгэмж 31 албан хаагчдад 4650000 төгрөг, 1 улсын байцаагч өвчний улмаас нас барсан тул 1 сарын үндсэн цалинтай тэнцэх	100%

		<p>хэмжээний мөнгөн тусламж олгож, 2019 онд 14 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах бөгөөд 12-36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг нь төсөвт суулган өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> - Тус байгууллагад ажиллаж байсан үе, үеийн ахмадуудаа Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан НМХГ-ын дарга болон удирдлагууд мэндчилгээ дэвшүүлж Тамгын газрын 73 албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулсан. - 2019 онд 389 ажилтан, албан хаагчдыг Төрийн дээд болон МХЕГ, НМХГ, нутгийн захиргааны болон салбарын бусад шагналаар шагнаж урамшууллаа. - Тус газар Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран Тамгын газар, Чиглэлийн хэлтэс, төв лабораторийн нийт 230 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. - 2017 оноос эхлэн Түшээ дээд сургуультай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд 2019 онд 2 дугаар ангид 27, 1 дүгээр ангид 16, Удирдлагын академи, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУИС, Билиг дээд сургуулиудад давхардсан тоогоор нийт 80, ОХУ, Япон, Украин, Испани, Франц, Израйл, Австри, Чех, Герман, Хятад, Солонгос, Вьетнам гадаад улсад урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан 38, нийт давхардсан тоогоор 118 албан хаагчдад цалинтай чөлөө олгосон байна. - Хүний нөөцийн мэдээллийн сан, байгууллагын дотоод удирдлагын цогц системийг байнга баяжуулж, удирдлагыг мэдээллээр хангаж байна. Буцалтгүй тэтгэмж олгогдсон албан хаагчдын судалгаа, шагнал авсан албан хаагчдын судалгаа, сахилгын арга хэмжээ авсан албан хаагчдын судалгааг ангилж вэб сайтад байршуулсан. 	
5	<p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх</p>	<p>Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, дүгнэхдээ тогтоолыг үндэслэн дүгнэхээс гадна байгууллага дотоод зохион байгуулалтаараа албан хаагчийн тухайн жилд хөдөлмөрийн сахилга бат цаг ашиглалт, ажлын идэвх санаачилга, төрийн албан хаагчийн ёс зүй, тушаал шийдвэр үүрэг даалгаварын биелэлт, дүгнэдэг бөгөөд ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг ил тод тогтмол шинэчлэн байршуулан ажиллалаа. Тамгын газар болон хэлтсийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, удирдах ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг нэгтгэдэг. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг ub.inspection.gov.mn- д сар, улирал, хагас, бүтэн жилээр байршуулан ажиллалаа. Биелэлт 100%-тай байна.</p>	100%

ХЯНАСАН:
ОНХХ-ИЙН ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ЭНХЖИН